

## ТАНИЛЦУУЛГА

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Чуулганы нэгдсэн хуралдаанаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хуулийг мөрдөж эхэлсэн.

Тус хууль 5 бүлэг, 37 зүйлтэй бөгөөд Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6.2-т “Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.” гэж, мөн тус тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д “Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх” гэж тус тус заасны дагуу эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага бий болж байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх зорилтыг хэрэгжүүлэхдээ Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.5-д зааснаар Засгийн газар цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэхээр хүлээсэн үүргийнхээ дагуу Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-д нэмэлт оруулж, уг журмын дагуу ашигт малтмал болон газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөлт үзүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг 2021 онд баталж, тус хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уг хуульд гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг хуулиар зохицуулахаар тусгагдсан. Түүнчлэн Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа дуусгавар болсон, албан татвар (төлбөр, хураамж)-ын асуудлыг шийдвэрлэх нь

Монгол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах тул “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх эрх зүйн үндэслэлийг хуульд тусгах шаардлагатай байна.

Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар зөвхөн хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгохтой холбоотой эрхээ бусдад шилжүүлэх зохицуулалттай тул “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой чиг үүргийг шилжүүлж болох эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх нь чухал байна.

Түүнчлэн төрийн өмчит зарим хуулийн этгээд сул ажлын байрандаа ажилтан олж ажиллуулахад хүндрэл үүссэний улмаас гадаад ажилтан ажиллуулах зөвшөөрөл хүсэх тохиолдол сүүлийн жилүүдэд гарч, гадаадаас ажилтан авч ажиллуулах хэрэгцээ үүссэн. Гэвч тухайн байгууллагын төсөвт гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх төсөв батлагддаггүй тул гадаад ажилтан авч ажиллуулах боломжгүй болж, улмаар ажиллах хүчнээс хамааралтайгаар үйлчилгээний чанар, хүртээмж муудах бодит нөхцөл байдал бий болж байна. Иймд төрийн өмчит зарим хуулийн этгээдийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлж болох асуудлыг хуульд тусгах хэрэгтэй байна.

Дээрх зорилт, арга хэмжээ, нөхцөл байдлыг үндэслэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд дараах агуулгатай нэмэлт, өөрчлөлтийг тусгахаар хуулийн төслийг боловсруулсан болно:

1. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой эрхээ Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шилжүүлж болохоор;

2. Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас бусад төрийн өмчит хуулийн этгээдийн гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газрын шийдвэрээр хөнгөлж, чөлөөлж болохоор;

3. Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан тохиолдолд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлж болохоор тус тус тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй бөгөөд ажил олгогч, хөрөнгө оруулагчийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд буюу төрд төлж байгаа гадаад ажилтны ажлын байрны төлбөр хөнгөлөгдөж, чөлөөлөгдөх, улмаар зардлаа хэмнэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжтэй, шуурхай байдлыг бий болгох зэрэг эерэг үр дүн гарна.